



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР**

2024 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 02

Бор-Өндөр сум

**Бор-Өндөр сумын төвийн өвөлжилтийн  
бэлтгэл ажлыг хангуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5, 25.1.12 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.3 дахь хэсэг, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 03 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

**Нэг. “Монголросцветмет” ТӨҮГ-ын харъяа  
Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэрийн захиралд:**

1.1. Сумын төвийн дулаан, цэвэр усны усан хангамжийн найдвартай байдлыг хангах ажлын хүрээнд шугам сүлжээ, насос, мотор, үлээгчийн засвар үйлчилгээ тохируулгыг бүрэн хийж, өвлийн улиралд тасалдалгүй ажиллах бэлтгэл ажлыг хангах,

1.2. Халаалтын улиралд таднах агаарын температурын хамааралтайгаар хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй хангаж, батлагдсан температурын графикын дагуу, технологийн горимыг барьж ажиллах,

1.3. Дулаан цэвэр усны хангамжийн саатал, ослын үед ажиллах багийг ~~томилгоождолж, гэмтэл саатлыг арилгах талаар авч хэрэгжүүлж буй ажлын талаар сумын~~ Онцгой комисс, шуурхай штабт тогтмол шуурхай мэдээлж ажиллах,

1.4. Дулаан хангамжийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2024 оны 11 сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд дулааны шугамаас огтолгоо авахгүй байх, сүлжээнд шинээр хэрэглэгч холбохгүй байх.

1.5. 2024-2025 оны халаалтын улиралд шаардагдах нүүрсний 50 хувиас доошгүй нөөцийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор татан авч, нөөц бүрдүүлэн ажиллах,

**~~Хоёр. Бор-Өндөр сумын Хот тохижилт ОНТҮГ-ын даргад:~~**

2.1. Халаалтын улиралд түлээ нүүрсний үнс, хог хаягдлыг хуваарийн дагуу татан тээвэрлэх ажлын техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг 2024 оны 09 сарын 20-ны дотор хангаж ажиллах,

2.2. Нийтийн эзэмшлийн орон сууцны хонгил, бохирын шугамын засвар үйлчилгээг 2024 оны 09 сарын 10-ны өдрийн дотор хийж дуусгах

2.3. Сумын доторх хатуу хучилттай авто замын цас арилгахад шаардлагатай давс, цас цэвэрлэх төхөөрөмжийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны дотор бэлтгэж ажиллах,

**Гурав: Бор-Өндөр сумын 1-4 дүгээр багийн Засаг дарга нарт:**

3.1. Нийтийн эзэмшлийн орон сууцны орц, хонгилыг хариуцсан эзэнтэй болгож, ~~хаалга, цонх, халаалтын шугамын засвар үйлчилгээг 2024 оны 09 сарын 10-ны өдрийн~~ дотор хийж дуусгах,

3.2. Халаалтын улиралд болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Бумбат" 3 дугаар баг, "Уурхайчин" 4 дүгээр багийн айл өрхийн түлээ, ~~нуурсний хог хаягдлыг галд тэсвэртэй материалаар хийсэн саванд хийж буй эсэхэд Онцгой~~ байдлын хэлтэстэй хамтарч хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж 2024 оны 09 сарын 25-ны дотор авч хэрэгжүүлсэн ажлын тайланг Засаг даргын тамгын газрын Хөдөө аж ахуйн тасагт хүргүүлэх,

**Дөрөв: Төсвийн шууд захирагч, албан байгууллагын дарга нарт:**


4.1. Аймгийн Засаг даргын 2024 оны 03 тоот албан даалгавар, сумын Засаг даргын 2024 оны 02 тоот албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж, авч хэрэгжүүлсэн ажлын талаарх тайланг 2024 оны 09 сарын 20-ны өдөрт сумын Засаг даргын тамгын газрын Хөдөө аж ахуйн тасагт хүргүүлэх,

4.2. ~~Өөрсдийн эзэмшлийн шугам сүлжээнд урсгал засвар хийж, дулаан хангамж~~ хүлээн авах бэлтгэл ажлыг хангаж, батдагдсан төсөвт багтаан шийдвэрлэх,

**Тав: Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт:**

5.1. Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч Х.Галбадрах-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ